

Хуульзүй, дотоод хэргийн сайдын
2017оны....дүгээрсарын..... -ны
өдрийн.....дугаарын тушаалын
хавсралт

МЭДЭЭЛЛИЙН САНД МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ШАЛГАХ,
ҮНЭЛЭН ШИНЖЛЭХ, АШИГЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХҮЛЭЭН
АВАХ, ХУВААРИЛАХ, ҮР ДҮНГ ТООЦОХ, ЛАВЛАГАА
ӨГӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь цагдаагийн байгууллагын мэдээллийн сан /цаашид “Мэдээллийн сан” гэх/-д мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, **Төрийн болон албаны нууцын тухай хууль** Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, энэ журмыг мөрдөж ажиллана.

1.3.Энэ зүйлийн 1.1-д заасан мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хуваарилах, хүлээн авах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх зэрэг үйл ажиллагааг Цагдаагийн төв байгууллагын даргын баталсан хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

Хоёр.Мэдээллийн сан

2.1.Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуулийн 61.2 дахь хэсэгт заасны дагуу уг сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ба хуульд өөрөөр заагаагүй бол цагдаагийн байгууллагын нууцын зэрэглэлд хамаарна.

2.2.Төв, орон нутгийн цагдаагийн байгууллага /цаашид “байгууллага” гэх/ мэдээллийн санг ашиглахдаа холбогдох стандарт /Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм MNS/ISO 17799:2007, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага MNS/ISO 27001:2007/-уудыг мөрдөж ажиллана.

2.3.Мэдээллийн санд нэвтрэх эрхийг тодорхойлсон жагсаалтын төслийг цагдаагийн төв байгууллагын мэдээллийн технологи хариуцсан нэгж боловсруулан бэлтгэж, хянан, Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр батлуулах ба түүнд дагаж мөрдөх хугацааг заана.

2.4.Дараах чиглэлээр мэдээллийг нэгтгэн боловсруулна:

2.4.1.тактикийн шижилгээ буюу сэжигтэй этгээд, үйл явдлуудын ерөнхий дүр зургийг тодорхойлох, гэмт төлөвлөгөө, яриа өгүүллийг судалж, тактик боловсруулах зорилгоор мэдээлэл, баримт сэлтийг шинжлэн дүгнэнэ.

2.4.2. стратегийн шинжилгээ буюу чиг үүргээ хэрэгжүүлэх стратеги зорилтыг боловсруулж, түүнийг хангах арга замыг тодорхойлох зорилгоор олон нийтийн санаа бодол, хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл цуглуулах, мэдээлэл, баримт сэлтийг шинжлэн дүгнэнэ.

2.4.3. тодорхой гэмт этгээд, гэмт явдлыг тодорхойлох шинжилгээ буюу хоорондоо ижил төстэй онцлогшинжтэй гэмт явдлууд, гэмт этгээдүүдийн ижилсэх болон ондооших чанаруудыг тодорхойлж гэмт явдлуудын харицан хамаарал бүхий байдлыг судлан тогтооно.

2.4.4. гэмт явдлын чиг хандлага, хэв шинжийг тодорхойлох буюу өдөр тутам мэдээллийн санд буй мэдээллийг судалж, гэмт явдлын цаашдын чиг хандлага, харилцан хамаарал, ул мөр, нотлох баримт судлалын талаар ижилсэх болон ондооших шинж чанаруудыг тодорхойлно.

2.4.5. илтгэл, танилцуулга бэлтгэх буюу алба, хэлтсийн ажлын үр дүнг хэлэлцэх, цаашдын арга хэмжээг өөрчлөх, боловсронгуй болгох асуудлуудыг хэлэлцэх үед алба хаагчдад танилцуулна.

2.4.6. мэдээллийн албан ёсны бюллетень гаргах буюу гэмт явдлуудын ижилсэх болон одооших шинж тэмдгүүдийг, байнга гэмт хэрэг үйлдэгч этгээдүүдийн талаар мэдээллийн солилцоог хангахын тулд мэдээллийн шинжилгээний байгууллагаас тогтмол гаргана.

2.4.7. ANASPA шинжилгээ буюу хүнд гэмт хэрэг мөрдөх болон их мэдээллийн шинжилгээний дүгнэлтэнд үндэслэн мөрдөх шаардлагатай ноцтой гэмт этгээдүүдийн талаарх мэдээллийн урсгалыг ойлгоход дөхөмтэй хүснэгт хэлбэрээр гаргаж танилцуулна.

2.5. Цагдаагийн төв байгууллага, харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хариуцсан болон олон нийттэй харилцах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагч мэдээлэл нэгтгэн боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гурав. Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах

3.1. Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуулийн 61.1 дэх хэсэгт заасан тоо бүртгэлд тулгуурлан мэдээллийн санг үүсгэж, үйл ажиллагаандаа ашиглана.

3.2 Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2-т заасан ял шийтгүүлсэн ; 61.1.3-т заасан эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан; 61.1.4-т заасан эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан хүний талаар; 61.1.5-д заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн; 61.1.7-т заасан өршөөл, уучлалд хамрагдсан хүмүүс; 61.1.20-д заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хуулийн этгээдийн талаар мэдээллийн сан үүсгэх, ашиглах, лавлагаа өгөхөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга нарын **Хууль зүй, дотоод хэргийн сайдын** хамтарсан тушаалаар батлагдсан журмыг баримтална.

3.3. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь энэ журмын 3.1-д дурьдсан тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд мэдээлэл нэгтгэн боловсруулах нэгж нь мэдээллийг тухай бүр баяжуулж, холбогдох хууль, журамд заасны дагуу мэдээллийн санд оруулна.

3.4. Мэдээллийн санд мэдээлэл оруулахдаа нэвтрэх эрх бүхий алба хаагч өөрийн нууц үг, хандах эрхийн дагуу системд нэвтрэнэ.

3.5.Мэдээллийн сан, цагдаагийн дотоод сүлжээнд нэвтрэх эрх авах, өргөтгөх, өөрчлөх, цуцлах тухай асуудлыг мэдээллийн технологи хариуцсан нэгж хариуцна.

3.6.Мэдээллийн санд хандах эрх нь мэдээлэлтэй танилцах, оруулах, засварлах, нөхөн бүртгэх, өргөтгөх, баталгаажуулах гэсэн төрөлтэй байна.

3.7.Цагдаагийн алба хаагч мэдээллийн санд мэдээллийг үнэн зөв оруулах үүрэгтэй.

3.8.Цагдаагийн алба хаагчийн мэдээллийн санд оруулсан мэдээлэлд тухайн байгууллагын дарга, эрх бүхий алба хаагч хяналт тавьж, алдаатай, эсхүл буруу оруулсан мэдээллийг зөвтгүүлэх арга хэмжээг авна.

3.9.Мэдээлэл нэгтгэн боловсруулах нэгж нь мэдээллийн санд оруулж буй мэдээллийн үнэн зөв, мэдээлэл оруулах, харах, засварлах, нөхөн бүртгэх, баталгаажуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх үйл ажиллагаанд хяналт тавина.

3.10.Мэдээллийн санд оруулах мэдээллийг цаг алдалгүй оруулж, мэдээллийн сан үүсгэх, мэдээлэл цуглуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн ашиглалтыг хариуцсан нэгж болон цагдаагийн байгууллагын дарга нар хүлээнэ.

3.11.Мэдээллийн сангийн ашиглалтын талаар хийсэн үйлдэл, хандалт зэрэг нь системд бүртгэгдэж байхаар бүртгэл /log/-ийг хөтлөхөөр зохицуулна.

Дөрөв.Мэдээллийг үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах

4.1.Мэдээллийн сангийн мэдээллийг үнэлэн шинжлэхдээ дор дурдсан судалгаа, шинжилгээний ерөнхий аргыг ашиглана:

4.1.1.статистик арга;

4.1.2.ажиглалт хийхарга;

4.1.3.ярилцлага хийхарга;

4.1.4.таамаглал дэвшүүлэхарга;

4.1.5.зэрэглэл тогтоох арга;

4.1.6.загварчлалын арга;

4.1.7.ижил төсөөлөл харьцуулалтын арга;

4.1.8.системийн анализ гэх мэт.

4.2.Мэдээллийг үнэлэн шинжлэхдээ дараах чиглэлийг баримтална:

4.2.1.эрсдэл бий болох нөхцөл байдал, хор уршгийг тогтоож, мэдээлэлд зэрэглэл тогтоох, түүнд дүн шинжилгээ хийх;

4.2.2.тухайн мэдээлэлтэй холбоотой эмзэг байдлын үнэлгээ хийх;

4.2.3.эрсдэлийг бууруулахад чиглэсэн хүч, хэрэгслийн чадавхийн үнэлгээ хийх;

4.2.4.нөхцөл байдалд тулгуурласан мэдээллийн үнэлгээ хийх.

4.3.Мэдээллийг үнэлэн шинжлэх нь дараах зэрэгтэй байж болно:

- 4.3.1.судалгаа шинжилгээний чиглэлээр ашиглах;
- 4.3.2.дотоод үйл ажиллагааны чиглэлээр ашиглах;
- 4.3.3.байгууллагын дарга, холбогдох алба хаагчид танилцуулах;
- 4.3.4.дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;
- 4.3.5.хойшлуулшгүй арга хэмжээ авахуулах;
- 4.3.6.нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.

4.4.Мэдээллийн сан дахь мэдээллийг цахим болон биет байдлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ. Энэ тохиолдолд шуурхай, аюулгүй байдал, нууцлалыг хангана.

4.5.Мэдээллийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ирүүлсэн мэдээлэлтэй танилцаж, зохих арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ.

4.6.Мэдээллийн санг цагдаагийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглана.

4.7.Мэдээлэл нэгтгэн боловсруулах нэгж нь энэ журмын 3.1-д заасан мэдээлэлд тулгуурлан болзошгүй нөхцөл байдал, үйл явцын талаарх урьдчилсан таамаглал, төсөөллийг гаргаж, түүнд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах санал, зөвлөмжийг боловсруулна.

Тав.Мэдээллийг шилжүүлэх, үр дүнг тооцох

5.1.Мэдээлэл нэгтгэн боловсруулах нэгж нь энэ журмын 4.7-д заасны дагуу шаардлагатай мэдээллүүдийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шалгах, үнэлэх, ашиглах байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

5.2.Энэ журмын 5.1-д заасны дагуу мэдээллийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд хариу мэдэгдэнэ.

Зургаа.Мэдээллийг хуваарилах, лавлагаа өгөх

6.1.Мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагчийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглах бөгөөд эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтан, олон улсын цагдаагийн байгууллагад тэдний хүсэлтээр холбогдох мэдээллийг өгч болно.

6.2.Энэ журмын 6.1-д заасан мэдээлэл хүссэн зорилго, өгсөн мэдээллийн талаар бусдад задруулахыг хориглоно.

~~6.3.Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх алба, Нийтийн хэв журам хамгаалах газар, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар, түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Монгол банк, Үндэсний дата төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь мэдээллийн хэрэглэгч байна.~~

6.4.Мэдээллийг хэрэглээнд оруулж хуваарилах, мэдээллийн хэрэгцээг хангах үүргийг Мэдээлэл нэгтгэн боловсруулах нэгж хариуцна.

Долоо.Бусад

7.1.Мэдээллийн сангаас мэдээлэл алдагдах, утсан тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2.Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хангах үүргийг цагдаагийн төв байгууллагын мэдээллийн технологи хариуцсан нэгж хариуцна.

---oOo---